

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэгмэдийн Оргодол	Дугаар	L136
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Түвшинширээ
Төрсөн газар		Төрсөн он	1938
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Допанлин хийд, Хүйтэний хурал	Сүм хийдийн дугаар	СБТШ 030, СБТШ 031
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 1	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Допанлин хийд, Хүйтэний хурал

-Танай нутаг оронд ямар ямар хийд байв?

Түвшинширээ , Баяндэлгэр хоёрын заагт Бударганы хийд гэж олон ламтай хүрээ хийд байсан гэж ярьдаг. Арван хэдхэн км яваад Хүйтний худаг гэж бий Худгийн аманд хурлын цагаан толгойн овоо гэж бий. Тэнд цагаан толгойн хурал байсан гэсэн. Жалгын хурал ч гэж ярьдаг мөн Цагаан толгойн хурал ч гэж байсан. Мөн уулын заагт эндээс 30-аад км-т Их Лагт гэж бий тэнд Ламтаны хүрээ гэж том хийд байсан. Уул баяны Орлой мэргэн хутагт гэж лам байсан гэсэн. Орлой мэргэн хутагтын хийдийн түүрх одоо ч байгаа. Алтанбулаг дээр байгаа хийд бол Сэцэн хан аймгийн Хардал Жанжин бэйсийн хошуу гэж байсан. Гал шарын хошуу нутаг нь томорч 1749 онд Бага хардэл гэж нааш нь татсан гэж ярьдаг. Хошуу нутгаа тасрахад сүм хийд ард олон бас тасардаг. Энэ Доплин хийдийн анхных нь бас энд тэнд нүүн нутаглаж явсан гэж ярьдаг. Модонгийн ард нэлээд байсан гэсэн. 1960-аад онд дөрвөлжин чулуун байшингийн түүрх нь байсан. Эрдэмтэй лам нар их байсан гэсэн ч амьдрал ахуй нь тарчиг байж. Тэгээд газар нутаг нь догшин юм байна лам нар нь эрдэмтэй байж нутаг сэлгэхэд гэмгүй юм байна гээд Алтанбулагийн зүүн ширээ дээр, одооны хийд байгаа Алтанбулагийн баг байгаа газар 1880 аад оны үед шав нь тавигдаж төвлөрсөн.1966 онд Чүлтэмжанцан гэдэг өвгөн байсан 86 настай. Тэр хэлэхдээ манай Алтанбулгийн хийд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

чинь намайг 2 настай байхад энэ булгийн зүүн дээр шилжиж ирсэн юм гэнэлээ гэж байсан . Тэр хүн 1966 онд 86 настай таалал төгссөн. Тэрнээс үзэхэд Доплин хийд 1880-1882 онд байсан нь дамжиггүй. 1920 хэдэн оны судалгаагаар архивийн материалд Эрх гүний хошуу ,Өлзийт уулын хошууны хийд гэж Малгар уулын баруун урд байна гэж тодорхойлж байсан юм гэнэлээ. Алтанбулгийн хийд 15 жилийн ойгоо 2005 онд хийсэн түүндээ зориулж ном гаргасан. Хийд дээр ном нь байгаа.

-Эрх гүний хошуу хийд маань хэр олон ламтай, ямар хуралтай, хэр олон дугантай байсан юм бол?

500 гаруй ламтай 6 дацантай, Чойрын дацантай. Жил бүр гавжийн дамжаа барьдаг хийд дээрээ чойрын номоо шүүлгүүлж мяндаг тушаал өгдөг байсан гэж байгаа. Хэнтий аймгийн дотоодыг хамгаалах газраас ирж Эрх гүний хошуу хийдийн лам нарыг өвлийн тэргүүн сарын зулын 25 маргааш гэж байхад барьж эхэлсэн гэсэн. Тэр нь 1937 оны 11 сарын 20 юм билээ. Хийдийн тэргүүн хамба Шаравын Ёндон-Осор гэж байсан гэж архивт байдаг. Хошууны маарамба Ёндон маарамба , Чогсом унзад , Гончиг унзад гэх мэт 8 лам 1 хар хүн дандаа гавж мяндагтай хүмүүсийг баривчилж байсан. 1990 он гараад шашин шүтлэг чөлөөтэй болоход тэр үеийн лам нараас үхэж үрэгдсээр байгаад бага залуу байсан 20-иод хүн үлдсэн .Тэдэн дотор нэг нь 38 онд баригдаад ял шийтгэлээ эдлээд ирсэн гавж мяндагтай хүн байсан. Сүүлд 3 лам үлдсэн байснаас Хамба лам Шаравсамбуу гэдэг лам 89 настай энэ хүрээнд сүүж 2006 оны 12 сард нас барлаа. Гэсгүй лам Ёндон гэж байсан 2006 оны 4 сард 89 настайдаа нас барлаа. Шагдарсүрэн гэдэг лам нь 93 настай нас барлаа.

-Тэд ямар мяндаг цолтой хүмүүс байв?

Ёндон бол гүмбэнд очиж 1997 онд гэлэн сахил хүртсэн.Тэнд очиход дөрвөн Ренбүүчий байсан гэсэн тэр улсуудаар шүүлгээд гэлэн сахил авсан гэсэн. Урьд шашин дэлгэр байхад Ар монголоос нэг л лам энд ирж гэлэн санаваар хүртэж байсан. Шинэ цагийн үед та хүртлээ. Та хоёр л манай энд ирж гэлэн санаваар хүртэж байна гэж байсан гэсэн.1990 оноос залуу лам нар шавилан суугаад одоо 20 хэдтэй 10 гаруй лам нар байна. Биеэ даагаад ойр зуурын хурлуудыг хурдаг. Гүнрэг, оройн ерөөл, цагийн хурлуудыг бүгдийг нь хурна. Сахиусны 17-нд сахиус Гомбо сахиусаа тахина, Зуны дунд сарын 16-нд Намсрай бурхнаа тахиж даллага авна. Зуны тэргүүн сарын 16-нд бурхан багшийн гурван дүйчэн өдөр хийдээс хэлмэгдсэн болон хүрж байсан лам нарынхаа нарынхаа хойчийн буянд Гавжийн чоги хурдаг. Мөн сүсэгтэн олонд аврал айлтгалын номуудыг хүрж өгдөг. Хийдийн 15 жилийн ойгоор Чойрын дуган нэртэй шинэ дуган бариад баян Намсрай, Манзушир зэрэг хэдэн том бурхан залсан.Одоо Манла бурхан залах юм гэнэлээ. Өөрийнх нь үндсэн шүтээн нь Махгал бурхан. 1990 оноос эхлээд Гомбо сахиусаа залсан хуучин Гомбо сахиустай байсан . Модонгийн хурал гэж байхад гал шарын хошууны хүн Агваанлуvsан цорж Намсрай хамба гэж байгаа. 1797 оны үед Модонгийн худгийн энд төрсөн хүн. Түүхэнд анх ламын гэрт төрсөн. Тэр намайг эхээс мэндэлж байхад хонхны дуу сонсогдож байсан тэгээд ямар ч байсан хурал шажинтай газар эргэж төрсөн юм байна гэж бодож байсан гэж түүхээ бичиж байсан.Тэр нь Модонгийн хурал байсан. Тэнд Божоо сайд энэ тэр Гомбо бурхан тахиж байсан тэр нь амь орж улаан цагаан хөөс сахарсан гэж байгаа. Тэгээд хийд дээр залсан. Тэгээд тэр бурхан хадгаар ороосон бурхан Махгалын тэр ард нь залагдаж байдагсан гэж өвгөн хамба ярьж байсан. Тэр Махгалыг үндсэн шүтээнээ болгосон түүх нь энэ.

-Агваанбалдан цоржийн тухай түүх яриануудаас?

Агваанлуvsан цорж нь 1749 онд хошуу Гал шарын хошуунаас тасарсан болохоор хошуу байр суурь муутай байж. Тэрийг дагаад хурал номын газар ч байраа олохгүй нүүдэллээд явсан байна. Тэрний улмаас л анх Галшарын хийд дээр сууж байсан юм гэнэлээ. Тэгээд Энэтхэг Лхас Төвдийн оронд очиж номын эрдмээ шалгуулаад зуураа явж байхад нь Төв аймгийн нутагт Даян дээрхийн бөө гэж айхтар бөө хүн байсан тэр замд нь цагаан морьтой ирж хадаг яндар болоод ганц сайн хүн

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ирэх юм гэж дуулаад гээд явган заларч явахад нь эмээл дээрээ суулгаад өөрөө араар нь сундалж гэртээ аваачиж цай сүү болон авдраа уудлалж уудалж манайд ганцхан ариухан юм бий эндээ гэж хадаг 50 лангийн ембүү гарган бариад за миний сүүлчийн ажлыг та даагаарай гэж би урдаас сайн хүн Жанчивсэнгэ морилж Богдын хүрээ орох гэж байна гэдгийг мэдээд тантай л уулзах гэсэн миний хэрэг бүтлээ гэж байсан гэсэн. Тэгээд тэр хүн Хүрээнд очоод Дашчоймболын дацанд хүжин өргөж байсан юм гэнэлээ. 1937 онд хийд балартал Цагаан дуурсахын хүжин гээд мөнхийн хурал хурж байсан юм гэнэ лээ. 1837-1846 он хүртэл хүрээний чогжоо хурж байсан юм байна лээ.

-Эрх гүний хошуу хийд хэдэн дацантай байсан юу гэдэг нэртэй байсан байв?

Чойр, Манба, Дүйнхор, Жүд, Цогчэн, Их дуган гээд 6 дацантай байсан. 1937 оноос лам нарыг нь барихыг нь бариад 20 - иодхон лам үлдсэн гэсэн. Саяхан болтол 2 дуган нь байсан. Дүйнхорын дуган нь 1969 онд хоршооны бараа хурааж байгаад шатсан. Манбын дуганд Өлзийт сум нэгдлийн ноос түүхий эд хийж байсан. Дараа нь хойш төлөг борлон тэжээдэг байсан. 1970-аад оны үеэс хашааг нь аваад нураад дууссан даа. 1991 онд шинэ хийдээ Чойрын дуганыхаа суурин дээр барьсан юм гэнэ лээ. 2003 оны 10 сараас 2005 оны 8р сар хүртэл далайцтай ажил зохион байгуулж. 2004 онд чулуун хашааг нь тэлээд өргөтгөж Чойрын дуган гэдгийг шинээр байгуулсан 2005 оны 8 сарын 6-8-ны хооронд ойгоо хийсэн. Ой зохиосон ажлын талаар кино хийсэн. Сайхан болж өнгөрсөн. Ямар хурал хурж байсан ямар дэг жаягтай байсан хийдийн түүхийн талаар номон дээр дэлгэрэнгүй бий.

Алтанбулгийн хийдийн төвд нэр нь юу гэдэг байв ямар материалаар барисан байв?

Допанлин гэдэг байсан.

Хийдийг хуучин тоосго чулуу модоор ч барьсан гэдэг. Их дуган, Чойрын дуган хоёрыг модоор барьсан байсан.

Сүүлийн 2 дуганыг Хятадууд чулуугаар барьсан юм гэнэлээ. Дөрвөлжин чулууг залбируулаад өрсөн байдаг байсан.

Сүүлийн хоёрыг хөх тоосгоор барьсан.

- Хийдээс гарсан олонд алдартай лам нар ямар хүмүүс байв?

Хийдээс гарсан олонд алдаршсан их эрдэмтэй лам гэвэл сүүлийн баригдсан хийдийн хамба Цэвээн багш гэж ярьдаг Ланди багш ч гэдэг. Мянд -Осор гэдэг хүн Дашчоймболд унзад байсан. Мөн манай энд байсан Даржаа гэдэг хүн байсан. Тэрнийг хошуу ноён бичиг явуулж хамбаар суу гэж тэгээд хошуу ноёны зарлиг гээд аваад ирсэн юм гэнэ. Тэгэхэд Гандан хүрээнийхэн Дашчоймболын нэг эрдэмтэй хүн зүүншээ явчихлаа гэж байсан. Энэ хийд дээр чинь Төвдийн том лам гэгээнтэн Чамхар гэгээн лам 2 удаа заларч ирсэн гэнэ. Сүүлд нь залрахдаа Алтанбулгийн шилжин байхад нь өөрөө мэдээд зохион байгуулж арвайн гурил зуурч шидээд Дүйнхорын дуганы шавыг тавьж байсан гэж ярьдаг.

-Хийд дээр ном барладаг үйлдвэрлэдэг байсан болов уу?

Ном барлаж байсныг мэдэхгүй.